



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2010 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ ТУХАЙ

Нийслэлийн Засаг даргын 2009 оны 309 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 14 тоот зөвлөмж, Нийслэлийн Засаг даргын 2010 оны 299 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд автотээврийн хэрэгслээс гарах бохирдлыг бууруулах зорилгоор “Автотээврийн хэрэгсэлд шингэрүүлсэн нефтийн хийн төхөөрөмж суурилуулах” 2009 оны 12 дугаар сарын 03-ний өдөр байгуулсан АБ/10 дугаартай гэрээт ажлын хэрэгжилт, гүйцэтгэлийг хүлээж авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилон ажилуулсугай.

Ч. Батсайхан / Ажлын хэсгийн ахлагч НАЧА -ны дэд дарга /

П. Ариунаа / Нягтлан бодогч/

Б. Сүхбаатар / Хүний нөөц, Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн/

О. Алтангэрэл / Автотээврийн бохирдол хариуцсан мэргэжилтэн/

Хоёр. “ЮниГаз” компаний хэрэгжүүлсэн төслийн ажлын үр дүнтэй танилцан, дүгнэлт гарган, ажлын гүйцэтгэлийг хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч / Ч. Батсайхан/ -д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХЦОГ